



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/447.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Хуучин нисэхээс Хүүхдийн парк хүртэлх авто замын гэрэлтүүлгийн засварын ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Баярсүх	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Н.Цацралцэцэг	- Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч
	У.Пүрэвдорж	- Ховд "Цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ий Ерөнхий инженер
	Б.Түмэнжаргал	- Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
	Д.Ариунболд	- Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ц.Сувдаа	- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн Жаргалант сумын Хуучин нисэхээс Хүүхдийн парк хүртэлх авто замын гэрэлтүүлгийн засварын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-0107